



МОНГОЛ УЛС  
СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ  
ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 21 өдөр

Дугаар А/335

Баруун-Урт сум

Тусгай зөвшөөрөл олгох, сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 6.3, 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.1.3, 10.1.5, 12 дугаар зүйлийн 12.1, 16 дугаар зүйлийн 16.2.5, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.7 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Баруун-Урт сумын 2 дугаар багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй Б.Чулуунбаатар захиралтай “Асгат өндөр” ХХК-ийн “Баянзээрд” хүнсний дэлгүүр, Онгон сумын 3 дугаар багийн нутаг дэвсгэрт байрлах Д.Алтанхуяг захиралтай “Баяжих олон од” ХХК-ийн “Олон од” хүнсний дэлгүүр, Наран сумын 3 дугаар багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй Б.Сумъяа захиралтай “Эрдэнэ-Өлзийт-Ундрах” ХХК-ийн “Дэлгэр ундраа” хүнсний дэлгүүр, Баяндэлгэр сумын 6 дугаар багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй С.Цогтбаяр захиралтай “Наран соёмбо” ХХК-ийн “Соёмбо” хүнсний дэлгүүр, Мөнххаан сумын 4 дүгээр багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй Б.Эрдэнэбилэг захиралтай “Шинэ ангараг” ХХК-ийн “Дээж” хүнсний дэлгүүр, Мөнххаан сумын 4 дүгээр багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй Ш.Жавзмаа захиралтай “ЖОЖОН жавхлант” ХХК-ийн “Жавхлант” хүнсний дэлгүүр, Мөнххаан сумын 4 дүгээр багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй Г.Доржханд захиралтай “Мөнхийн булагт-Агь” ХХК-ийн “МБА” зоогийн газар, Баруун-Урт сумын 7 дугаар багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй Р.Мөнхсүх захиралтай “Бадрах хоймор” ХХК-ийн “Хоймор” зоогийн газар, Баруун-Урт сумын 7 дугаар багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй Б.Төрбат захиралтай “Өсөх ирээдүйн оргил” ХХК-ийн “Хөрш” хүнсний дэлгүүрийн согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрлийг 2022 оны 06 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн 2 жилийн хугацаатай сунгаж, Баруун-Урт сумын 4 дүгээр багийн “Насны дүүрэн өргөө” ХХК-ийн “Триллион” зоогийн газарт сул агууламжтай согтууруулах ундаагаар үйлчлэх, Баруун-Урт сумын 6 дугаар багийн “Ундрах баян шарга” ХХК-ийн “Гоё” хүнсний дэлгүүрт өндөр агууламжтай согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрлийг 2022 оны 06 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн 2 жилийн хугацаатай олгосугай.

2. Тусгай зөвшөөрөл сунгагдсан болон шинээр олгогдсон аж ахуй нэгжийн үйл ажиллагаанд байнгын хяналт тавьж, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө

2222010668

оруулалтын хэлтэс (Х.Энхцэцэг), Цагдаагийн газар (цагдаагийн хурандаа Б.Гантулга), Мэргэжлийн хяналтын газар (С.Нямжав), Стандарт хэмжил зүйн хэлтэс (Д.Эрдэнэбат), холбогдох сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Монгол Улсын холбогдох хууль, тогтоомжийг мөрдөн ажиллахыг дээрх аж ахуй нэгжүүдийн захирлуудад даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



М.ИДЭРБАТ